



МОНГОЛ УЛС ШАДАР САЙДЫН ТУШААЛ

20 16 оны 4 дугаар
сарын 15 -ны өдөр

Дугаар 34

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журамтай холбогдуулан "Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны заавар"-ыг боловсруулан баталж, хэрэгжүүлж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга /бригадын генерал Т.Бадрал/-д даалгасугай.

Монгол Улсын Шадар сайд



Ц.ОЮУНБААТАР

ГАМШГААС ХАМГААЛАХ САЙН ДУРЫН АЖИЛЛАГААНЫ НИЙТЛЭГ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны үндсэн чиглэл, зарчим, зохион байгуулалт, санхүүжилт, гамшгаас хамгаалах сайн дурын ажилтанд /цаашид сайн дурын ажилтан гэх/ тавигдах шаардлага, эрх, үүрэг, сургалт дадлага, нийгмийн баталгаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Сайн дурын ажилтны үйл ажиллагааны эрх зүйн үндэс нь Монгол Улсын Үндсэн хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж байна.

1.3. Сайн дурын ажилтан нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцсоноороо хууль тогтоомжийн дагуу эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

1.4. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.4.1. "Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагаа" гэж иргэн өөрийн хүсэлтээр гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцож байгаа оролцоог хэлнэ.

1.4.2. "Гамшгаас хамгаалах сайн дурын ажилтан" гэж гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагаанд оролцох бүртгэлтэй, энэ журамд заасан шаардлагыг хангасан иргэнийг;

1.4.3. "Гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг" гэж нэгдсэн зохион байгуулалтад орж, техник, багаж хэрэгсэл, материалаар хангагдан гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагаанд оролцох орон тооны бус бүрэлдэхүүнийг;

1.5. Сайн дурын ажилтныг тусгай сургалтанд хамруулан гамшгаас хамгаалах чиглэлээр мэдлэг, чадвар эзэмшүүлж, сайн дурын аврагч, аврагч-эмнэлгийн зааварлагч, аврагч-жолооч, аврагч-холбоочин гэх мэт төрлөөр бэлтгэнэ.

Хоёр. Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны үндсэн чиглэл

2.1. Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагаа нь дараах үндсэн чиглэлтэй байна:

2.1.1. гамшгаас урьдчилан сэргийлэх,

2.1.2. гамшгийн үед эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах үйл ажиллагаа,

2.1.3. гамшгийн дараах хүмүүнлэгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, сэргээн босгох ажиллагаа,

2.1.4. хэрэглэгч, олон нийтийн гамшгаас урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаа;

Гурав. Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны зарчим

3.1.Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагаа нь дараах зарчимтай байна:

3.1.1.хүмүүнлэг, энэрэнгүй, шуурхай байх;

3.1.2.хэрэглэгч, олон нийтийн эрх ашгийн төлөө байх;

3.1.3.ашгийн төлөө бус байх;

Дөрөв. Гамшгаас хамгаалах сайн дурын ажилтанд тавигдах ерөнхий шаардлага

4.1.Сайн дурын ажилтанд дараах ерөнхий шаардлага тавигдана.

4.1.1.Монгол Улсын иргэн, тус улсад хууль ёсоор оршин сууж байгаа гадаад улсын иргэн байна;

4.1.2.Насны доод хязгаар 18 нас байна;

4.1.3.Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагаа явуулах чиглэлээр мэдлэг, чадвартай байх;

4.1.4.Сэтгэцийн хувьд эрүүл байх;

Тав.Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны зохион байгуулалт

5.1.Сайн дурын ажилтныг “Гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагааны заавар”-ын дагуу бүртгэнэ. Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны зааврыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

5.2.Сайн дурын ажилтан нь бие даасан болон хэсгийн зохион байгуулалтад орж гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцоно.

5.3.Сайн дурын ажилтныг тусгай хөтөлбөрийн дагуу сургалтад хамруулсаны дараа гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцуулна.

5.4.Сургалтад хамрагдаж, үүрэг гүйцэтгэх мэдлэг, чадвар эзэмшсэн сайн дурын ажилтанд орон нутгийн онцгой байдлын байгууллагаас сургалтад хамрагдсан гэрчилгээ, үнэмлэх олгоно.

5.5.Сайн дурын хэсэг нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцохдоо тухайн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байгаа онцгой байдлын байгууллагын албан хаагч, бусад албан тушаалтны удирдлага дор үүрэг гүйцэтгэнэ.

5.6.Сайн дурын хэсэг нь үйл ажиллагаагаа орон нутгийн Засаг даргад тайлагнана.

5.7.Сайн дурын хэсэг нь гамшгаас хамгаалах чиглэлээр хэрэглэгч, олон нийттэй хамтарч ажиллаж, үйл ажиллагаагаа хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулна.

5.8.Сайн дурын ажилтан байгуулсан гэрээ, ажлын чиг үүргээ биелүүлээгүй, хууль тогтоомж зөрчсөн, ажил үүргээ сайн дураараа гүйцэтгэхээс татгалзсан, өөр орон нутагт шилжин суурьших болсон, цэргийн жинхэнэ албанд татагдсан, нас барсан, гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны гэрээг цуцалж, бүртгэлээс хасалт хийнэ.

Зургаа. Гамшгаас хамгаалах сайн дурын ажилтны эрх, үүрэг, хориглох зүйл

6.1. Сайн дурын ажилтан дараах эрх эдэлнэ:

- 6.1.1. гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны чиглэлээ сонгох;
- 6.1.2. ажиллах нөхцөлөөр хангагдах;
- 6.1.3. гамшиг, ослын бүсэд нэвтрэн үүрэг гүйцэтгэх;
- 6.1.4. ажлын чиг үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдээ, мэдээлэл авах;
- 6.1.5. аюулгүй байдал, хувийн мэдээллээ хамгаалуулах;
- 6.1.6. эрүүл мэндийн хохирлоо нөхөн төлүүлэх.

6.2. Сайн дурын ажилтан гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцоноороо дараах үүрэг хүлээнэ:

- 6.2.1. гамшгаас хамгаалах дайчилгаанд бэлэн байх, шаардлага гарсан тохиолдолд оролцох;
- 6.2.2. гэрээ болон ажлын чиг үүргээ биелүүлэх;
- 6.2.3. үйл ажиллагаандаа хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг сахих;
- 6.2.4. өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангах, бусдад туслах;
- 6.2.5. сургалт, дадлагад хамрагдаж мэдлэг, чадвараа дээшлүүлэх;
- 6.2.6. гамшгаас хамгаалах чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлаа холбогдох байгууллага, албан тушаалтанд тайлагнах;
- 6.2.7. хувь хүний болон нийгмийн ёс зүйн хэм хэмжээг сахих.

6.3. Сайн дурын ажилтанд дараах зүйлийг хориглоно:

- 6.3.1. гамшгаас хамгаалах үйл ажиллагааг тасалдуулах, хэвийн явуулах нөхцлийг алдагдуулахад чиглэсэн аливаа арга хэмжээг зохион байгуулах, оролцох;
- 6.3.2. гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцохдоо улс төр, шашны үйл ажиллагаа явуулах, хуулиар хориглосон аливаа асуудлаар ухуулга, сурталчилгаа хийх;
- 6.3.3. ажлын чиг үүргээс гадуур байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, мэдээ, мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, завших;
- 6.3.4. хувийн ашиг сонирхлын зөрчил гаргах, үнэмлэх, бичиг баримтыг хууль бусаар ашиглах;
- 6.3.5. мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэх, бусдад дамжуулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох үедээ согтууруулах ундаа хэрэглэх, бүдүүлэг зан авир гаргах.

Долоо. Орон нутгийн Засаг дарга, онцгой байдлын байгууллагын эрх, үүрэг

7.1. Орон нутгийн Засаг дарга гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагаанд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

- 7.1.1. орон нутгийн хэмжээнд гамшгаас хамгаалах сайн дурын ажилтныг бүртгэх, сургаж бэлтгэх;

7.1.2.нутаг дэвсгэрийн онцлог, гамшиг, ослын нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийг байгуулах, татан буулгах;

7.1.3.гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийг үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай техник, багаж хэрэгсэл, хувцсаар хангах;

7.1.4.сайн дурын ажилтантай гэрээ байгуулах, үр дүнг үнэлж дүгнэх;

7.1.5.сайн дурын ажилтны ажил үүргээ гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлэх, зайлшгүй шаардагдах зардлыг гаргах;

7.1.6.сайн дурын ажилтны аюулгүй байдлыг хангах, эрхийг хамгаалах;

7.1.7.сайн дурын ажилтныг шагнаж урамшуулах, шагналд тодорхойлох, олон нийтэд сурталчлан таниулах;

7.1.8.сайн дурын ажилтны бэлэн байдал, үйл ажиллагаанд хяналт тавих.

7.2.Орон нутгийн онцгой байдлын байгууллага гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагаанд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

7.2.1.гамшгаас хамгаалах сайн дурын ажилтныг элсүүлэх, сургаж бэлтгэхэд орон нутгийн Засаг даргад дэмжлэг үзүүлэх;

7.2.2.сайн дурын ажилтны мэдээллийн санг бүрдүүлэх;

7.2.3.сайн дурын ажилтны ажлын чиг үүргийг тодорхойлж батлах;

7.2.4.гамшгаас хамгаалах сайн дурын аврагчийг тусгай хөтөлбөрийн дагуу сургаж бэлтгэх;

7.2.5.сайн дурын ажилтныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх;

7.2.6.сайн дурын ажилтныг шагнаж урамшуулах, олон нийтэд сурталчлан таниулах;

7.2.7.гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийг байгуулах, бүрэлдэхүүнийг томилох, техник, багаж хэрэгслээр хангах асуудлаар орон нутгийн Засаг даргад заавар, зөвлөмж өгч мэргэжлийн удирдлагаар хангах.

Найм.Гамшгаас хамгаалах сайн дурын ажилтны сургалт, дадлага

8.1.Сайн дурын ажилтны сургалт, дадлагыг батлагдсан хөтөлбөрийн дагуу орон нутгийн хэмжээнд Засаг дарга, онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагатай хамтран зохион байгуулна.

8.2.Сайн дурын ажилтны сургалтын хөтөлбөрийг тухайн орон нутгийн онцгой байдлын байгууллагын дарга батална.

8.3.Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн дадлага, сургалтыг орон нутгийн онцгой байдлын байгууллагыг түшиглэн зохион байгуулна.

Ес.Сайн дурын ажилтныг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд татан оролцуулах

9.1.Сайн дурын ажилтныг шаардлагатай үед нэгдсэн удирдлага, зохион байгуулалтад оруулж үүрэг гүйцэтгүүлнэ.

9.2.Сайн дурынхны бэлэн байдлыг хангах арга хэмжээг орон нутгийн Засаг дарга, гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн дарга хариуцан зохион байгуулна.

9.3.Сайн дурын ажилтныг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд татан оролцуулахдаа “Гамшгийн үед хүч хэрэгслийг дайчлан гаргах журам”-ын дагуу зохион байгуулна.

9.4.Гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг нь шаардлагатай үед хэсгийн гишүүдийг шуурхай цуглуулах, үйл ажиллагаагаа явуулах тусгай заавар, төлөвлөгөөтэй байж болно.

Арав. Гамшгаас хамгаалах сайн дурын ажилтны нийгмийн баталгаа

10.1.Сайн дурын ажилтан гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох үед хөдөлмөрийн чадвараа түр алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон, амь насаа алдсан тохиолдолд түүнд болон түүний гэр бүлд онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчийн нэгэн адилаар тэтгэмж олгоно.

10.2.Ажлаас чөлөөлөгдөн гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн сайн дурын ажилтныг үндсэн ажлаа хийсэнд тооцож, тухайн байгууллага нь цалин хөлсийг нь хэвээр нь олгоно.

10.3.Сайн дурын ажилтны үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах зардал, томилогдсон газарт очих, ирэх замын зардал, эмнэлгийн үзлэг, вакцинжуулалтад хамруулах зэрэг зайлшгүй гарах зардлыг тухайн орон нутгийн Засаг дарга хариуцна.

10.4.Сайн дурын ажилтны байгуулсан гавъяа, зүтгэлийг үнэлж, төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн шагнал, урамшуулал олгох, нийтэд алдаршуулан сурталчлах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

10.5.Сайн дурын ажилтанд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцсон ажлын үр дүнгээр дараах урамшуулал олгож болно:

- 10.5.1.Хоногийн хөдөлмөрийн хөлс;
- 10.5.2.Тээврийн хэрэгсэл ашигласан бол шатахууны зардал;
- 10.5.3.Хоол, унааны зардал;
- 10.5.4.Бусад зардал.

Арван нэг.Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны санхүүжилт

11.1.Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

- 11.1.1.улсын болон орон нутгийн төсөв
- 11.1.2.олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө
- 11.1.3.төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санаачилгаар хуримтлагдсан тусламж, хандивын хөрөнгө
- 11.1.4.бусад эх үүсвэр.